


ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ МОНГОЛ УЛСАД

(2021 оны байдлаар)

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэж байна.

1. МОНГОЛ УЛС ЖЕНДЭРИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ОЛОН УЛСАД

Дэлхийн Эдийн Засгийн форумын 2021 оны дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр (Global Gender Gap index Report) Монгол Улс 0.716 оноотойгоор 156 орноос 69 дүгээр байранд жагссан бөгөөд энэхүү үзүүлэлтийг дөрвөн үндсэн хэмжигдэхүүн болох эдийн засгийн оролцоо ба боломж, боловсролын түвшин, эрүүл мэнд ба эсэн мэнд амьдрах чадвар, улс төрийн эрх мэдэл хоорондын жендэрт суурилсан ялгааны хувьслыг харьцуулан гаргадаг.



2021

Жендэрийн зөрүүтэй байдлын индекс	69	0.716
Эдийн засгийн оролцоо ба боломж	23	0.769
Боловсрол эзэмшилт	73	0.993
Эрүүл мэнд ба амьд гарах боломж	1	0.980
Улс төрийн эрх мэдэл	116	0.122

— Монгол Улс
— Дэлхийн дундаж

2020



Жендэрийн хөгжлийн индекс

1.049



Жендэрийн тэгш бус байдлын индекс

0.286

Жендэрийн хөгжлийн индекс 2015-2020



Жил бүр хүний хөгжлийн илтгэлээр улс орны жендэрийн хөгжлийн индексийг тооцож байгаа нь тухайн улс орны жендэрийн талаар хууль эрх зүй, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг харуулж байдаг. Манай улсын ЖХИ 2020 онд 1.049 болж, 2015 онтой харьцуулахад 0.006 нэгжээр нэмэгдсэн байна.

Жендэрийн тэгш бус байдлын индекс

Манай улсын жендэрийн тэгш бус байдлын индекс 2020 онд 0.286 болж, 2015 онтой (0.289) харьцуулахад 0.003 нэгжээр буурсан байна.




Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, Тогтвортой хөгжлийн зорилт 2030-ын хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхэд эмэгтэйчүүдийн улс төр дэх төлөөлөл болон ажиллах хүчний оролцооны түвшин хангалтгүй байна. Тухайлбал ажиллах хүчний оролцооны түвшинд эмэгтэйчүүдийн (51.8 хувь) эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс (66.8 хувь) 15.0 нэгж хувиар доогуур байна. Энэ нь эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх боломжийн хувьд болон цалин хөлс, орлогын хувьд жендэрийн ялгаатай байдлыг харуулж байна.

Парламентад суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь

	Нийт нэр дэвшигчид	Үүнээс эмэгтэй	Үүнээс эрэгтэй
1992	293	4	289
1996	302	8	294
2000	602	9	593
2004	244	5	239
2008	256	66	190
2012	544	174	370
2016	498	129	369
2020	606	151	455

2020 оны УИХ-д сонгогдсон гишүүдийн хүйсийн харьцаа



Монгол Улсын нийт сонгогчдын 51%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг бөгөөд тэд сонгуульд идэвхтэй оролцдог. Гэвч УИХ дахь тэдний төлөөлөл нь ердөө 17.1% буюу дэлхийн дунджаас 7.6%-аар бага байна.

Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий Хороо 2021

Монгол Улсын Их хурлын гишүүд, хүйсээр, сонгуулийн онуудаар



Нийт эмэгтэй нэрдэвшигчдээс 2020 онд парламентын гишүүдийн 17.1 хувь эмэгтэй гишүүн байгаа нь эмэгтэйчүүдийн төлөөлөл улс төрийн шийдвэр гаргах түвшинд хангалтгүй байгааг харуулж байна. Эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоог улс төрийн шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлснээр нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх байдал сайжрах боломжтой юм.

Эх үүсвэр: Сонгуулийн ерөнхий хороо, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн дүн, ҮСХороо

Мөн эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 9,67 жилээр богино болоод байгаа нь ноцтой асуудал юм.

9.7

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1992 онд 4.19 байсан бол 2.3 дахин өсч 2018 онд 9.67 болсон нь бодлогын түвшинд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай, ноцтой хэмжээнд хүрсэн байна.



Эх үүсвэр: ҮСХороо, Жендэрийн үндэсний хорооноос эрхлэн гаргасан "Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдал"-ын суурь судалгаа.



Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалт

Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй байна. Манай улсын хувьд анх удаа 2017 онд явуулсан судалгаагаар хамтрагчтай эмэгтэйчүүдийн 29,7% нь амьдралдаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол 17,3% нь бусдын зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн байна. Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэй 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртжээ.



Эх үүсвэр: ҮСХорооны “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа-2017”, ЦЕГ-ын Статистикийн тойм “Гэр бүлийн хүчирхийлэл”-2020

2. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

А. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН

- БНМАУ-ын 1924 оны анхны Үндсэн хуульд эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш шударга хандах талаар тусгасан нь 1992 оны Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний гүнзгийрүүлсэн агуулгаар уламжлагдсан бөгөөд уг үзэл баримтлалын дагуу Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталсан.
- Монгол Улсын Засгийн газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг (2013-2016), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг (2002-2015), (2017-2021) онуудад баталж үе шаттай хэрэгжүүлж байна.
- Бодлогод суурилсан төлөвлөгөөт үйл ажиллагааны хүрээнд 1996 оны Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай үндэсний хөтөлбөрөөс эхлэн тооцвол жендэрийн тэгш байдлын чиглэлээр нийтдээ 5 хөтөлбөрийн хэрэгжилт дуусгавар болжээ.
- 2013 оноос эхлэн салбар, орон нутгийн жендэрийн тусгайлсан бодлого, төлөвлөлтийг хөгжүүлж, одоогийн байдлаар 12 салбарт жендэрийн стратеги, бодлого, 21 аймаг, нийслэл, нийслэлийн 8 дүүрэгт оролцоонд суурилан боловсруулсан жендэрийн дэд хөтөлбөр хэрэгжиж байна.
- Үндэсний хөтөлбөр дуусч байгаатай холбогдуулан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний стратеги төлөвлөгөөг (2022-2031)”-г боловсруулж байгаа бөгөөд 2022 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.

Монгол Улс жендэрийн тэгш байдалд чухал ач холбогдолтой олон улсын дараах конвенцид нэгдэн орсон. Үүнд:

Нэгдэн орсон он	Конвенцийн нэр
1965	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц (1952) /1952 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1954 оны 7 сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон/
1969	<ul style="list-style-type: none"> • Тэгш шан хөлс олгох тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц (1951) /1951 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1953 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон/ • Эхчүүдийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц (1952) /1952 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталж, 1955 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон/ • Алагчилахгүй байх /ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц (1958) /1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон/
1974	<ul style="list-style-type: none"> • Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) /Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон/ • Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966) /Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон/
1981	<p>Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979) /Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</p>


Б. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Жендэрийн харилцаа нь нийгмийн амьдралын бүх салбар, чиглэлийг хамардаг тул жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо нь салбар болон нийгмийн оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах чадамжтай байхыг дэлхий нийтээр даган мөрддөг Бээжингийн мөрийн хөтөлбөрт чухалчлан заасан байдаг. Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг, Жендэрийн үндэсний хороо нь Монгол Улсын Засгийн газрын 2021


оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 107 дугаар тогтоолоор ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн 9 яамны Төрийн нарийн бичгийн дарга, төрийн бусад (9) болон төрийн бус (13) нийт 31 байгууллагын төлөөллийг багтаасан салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан зөвлөх чиг үүрэг бүхий дэлхийн тэргүүн туршлагын жишээ юм. Жендэрийн үндэсний хороо нь 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт 31 салбар хороо, төрийн захиргааны 14 төв байгууллага (яамд)-д салбар зөвлөлтэй, Хорооны Ажлын алба нь 14 ажилтантай, төрийн захиргааны төв байгууллагад 14, орон нутагт 31 жендэрийн мэргэжилтэнтэй ажиллаж байна. Мэргэжилтнүүд Жендэрийн салбар зөвлөл, хороодод нарийн бичгийн үүрэг гүйцэтгэж, жендэрийн асуудлыг үндсэн ажлын хамт хавсран гүйцэтгэж байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо

Үндэсний түвшинд:



Орон нутгийн түвшинд:



3. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САНХҮҮЖИЛТ

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаас хойш 2011-2019 онуудад жендэрийн асуудлаар 12,469,841 ам.долларын хөрөнгө зарцуулсны 452,000 ам.долларыг буюу 3.6 хувийг улсын төсвөөс, үлдсэн 96.4 хувийг Хөгжлийн албан ёсны туслалцаа (ХАЁТ)-ны хүрээний түншлэгчид олгожээ.

Жендэрийн тэгш байдлыг хангах санхүүжилт, үйл ажиллагааны чиглэлээр, 2011-2019



Эх үүсвэр: Монгол Улсад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2011-2019 онд хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, санхүүжилтийн тойм.

2019-2021 оны санхүүжилтийн байдал (сая төг.)

	Улсын төсөвт (Ерөнхий сайдын багцад)	Орон нутгийн санхүүжилт	Олон улсын байгууллагын төслийн санхүүжилт
2019	706.8	766.1	232.2 (ЖҮХАА) 464 (Салбарын яамд)
2020	555.9	478.4	489.0 (ЖҮХАА)
2021	350.7	-	279.1

4. ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах үүрэг бүхий байгууллагууд, түүний дотор ЖҮХ-ны Ажлын алба нь үйл ажиллагааныхаа хүрээнд дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо бүхий өргөн хүрээтэй түншлэлийг хөгжүүлэхээр чармайж байгаа бөгөөд ТХЗ-уудын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хөгжлийн үндсэн арга стратеги хэмээн үзэж бодлого, үйл ажиллагааныхаа чухал хэсэг болгодог НҮБ-ын тогтолцооны байгууллагууд, түүний дотор олон улсын санхүүгийн байгууллагууд, түүнчлэн Хөгжлийн албан ёсны туслалцааны хоёр талт бүх байгууллагатай хамтран ажиллаж байна.

- Жендэрийн үндэсний хорооны 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн ээлжит хуралдаанаар /2021-2023/ онд авч хэрэгжүүлэх онцлох үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа. Үүнд:
 - I. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг бэхжүүлэхэд анхаарч, хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх;
 - II. Монгол Улсад хүний эрхийг дээдлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаанд эрүүдэн шүүдэггүй, хүний эрхийг зөрчдөггүй улс болох;
 - III. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж, төрийн албан дахь авлига, хүнд суртлыг арилгах, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих замаар сайн засаглалыг хөгжүүлэх;
 - IV. Төрийн байгууллагын ажлын байрны бэлгийн дарамтын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, устгах арга хэмжээ авах;
 - V. Хөвгүүд эрэгтэйчүүдийн эрүүл зөв аж төрөх, мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах замаар чанартай урт наслалтыг дэмжих, тэдэнд зориулсан хөгжлийн төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 77 дугаар захирамжаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн бодлогын үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэхэд стратегийн дэмжлэг үзүүлэх, зөвлөх чиг үүрэг бүхий “Бодлогын зөвлөл”-ийг Жендэрийн үндэсний хорооны дэргэд

байгууллаа. Энэхүү зөвлөлд УИХ-ын 13 эмэгтэй гишүүд болон Засгийн газрын эмэгтэй гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөхүүд болоод УИХ-д суудалтай улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн холбоодын тэргүүн нарын төлөөллүүдээс бүрдэнэ.

/захирамжийг www.ncge.gov.mn сайтын эрх зүйн акт хэсэгт/

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдаж, хэрэгжсэний 10 жилийн ойг тохиолдуулан хуулийн үр дагаварын үнэлгээг Ажлын алба нь жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг болон судалгаа, зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэж, гарсан зөвлөмжийн дагуу тайланг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

/хуулийн үр дагаварын үнэлгээг www.legalinfo.mn, www.ncge.gov.mn сайтын ном эмхтгэл хэсэгт/

- “Залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ” судалгааг ХХААХҮЯ, Азийн Хөгжлийн Банктай хамтран Ядуурлыг бууруулах Японы сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй техникийн туслалцааны төслийн хүрээнд гүйцэтгэж, холбогдох байгууллагуудтай үр дүнг санал зөвлөмжийн хамт хэлэлцэж, судалгааг үндэсний түвшинд танилцуулав.

/судалгааг www.ncge.gov.mn сайтын судалгаа хэсэгт/

- Азийн сангийн “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд (ЭЭЧБ) болон Канадын Гадаад Хэргийн яамны дэмжлэгтэйгээр Хараат бус Судалгааны хүрээлэн (IRIM)-тай хамтран “Монголын жижиг болон бичил (албан бус) бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ”-г хийж үндэсний түвшинд танилцууллаа.

/судалгааг www.ncge.gov.mn сайтын судалгаа хэсэгт/

- ЖЕНДЭР БА ХӨГЖИЛ-2021 үндэсний чуулганыг Азийн Хөгжлийн Банк, Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгууллаа. Монгол Улсын Тогтвортой

хөгжлийн зорилгыг хангах нэг арга зам болохыг хүлээн зөвшөөрч чуулганы 3 салбар хуралдааны түвшинд 400 гаруй оролцогчид тус чуулганд оролцож илтгэл хэлэлцүүлгийг өрнүүлж чуулганаас гарсан зөвлөмжүүдийг холбогдох талуудад хүргүүлж ажиллаа.




















/зөвлөмжийг www.ncge.gov.mn сайтын ном эмхтгэл хэсэгт/

- Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх “Ажлын байрны бэлгийн дарамтаас” урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх арга зүйн зөвлөмжийг Төрийн байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчдад болон Төрийн байгууллагаас бусад бүх хуулийн этгээдийг удирдлага, ажилтан, ажил олгогч иргэнд зориулан боловсрууллаа.

/зөвлөмжийг www.ncge.gov.mn сайтын ном эмхтгэл хэсэгт/

- Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн агентлагууд, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон бусад хамтын ажиллагааны нийгэмлэг, төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. ЖҮХ-ны Ажлын албанаас санаачлан Гадаад харилцааны яамтай хамтран 2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн жендэрийн асуудлаар олон улсын хөгжлийн түншлэгчдийн уулзалтыг улирал тутамд зохион байгуулж байна. Тус уулзалт нь мэдээлэл болон санал солилцох замаар жендэрийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн уялдааг хангах, санхүүжилтийг оновчтой зарцуулах, жендэрийн талаар баримтлах төрийн бодлогын хэрэгжилтийг дэмжихэд хувь нэмэр оруулах юм.
- 2019-2024 онуудад ЖҮХ АА-аас олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран дараах томоохон төслүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:
 - Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техникийн туслалцааны төсөл /2019-2021/;

- Швейцарын хөгжлийн агентлаг болон НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” техникийн туслалцааны төсөл /2020-2023/;
 - Канад Улсын Гадаад Хэргийн Яамны дэмжлэгтэйгээр Азийн сан хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төсөл” /2020-2024/;
 - Европын сэргээн босголт хөгжлийн банкны (ЕСБХБ) “Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хөтөлбөр” төсөл /2021-2024/;
 - КОЙКА-ын санхүүжилтийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” /2021-2024/.
- ЖҮХ-ны гишүүн ТББ-ууд, бусад хүний эрхийн болон хүний хөгжлийн чиглэлээр ажилладаг ТББ-уудтай дараах чиглэлээр тогтвортой хамтран ажиллаж байна. Үүнд:
 - Жендэрийн дүн шинжилгээ, түүний дотор төрийн албан дахь жендэрийн тэгш байдлын асуудлаар судалгаа үнэлгээ хийх;
 - Жендэрийн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
 - Жендэрийн тэгш байдлыг хангах эрхзүйн бодлогын орчныг сайжруулах, сургалтын тогтолцоог хөгжүүлэх;
 - Улс төр, нийгэм, соёлын хүрээнд, түүний дотор шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт нөлөөлөл хийх;
 - Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй, түүний дотор ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх;
 - Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал нэвтрүүлэх.
 - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйн удирдлагаар хангах зорилгоор жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэхэд чиглэсэн зөвлөмж, үлгэрчилсэн загвар, аргачлал, судалгаа зэрэг шинжлэх ухааны үндэслэлтэй бүтээлүүдийг жил бүр эрхлэн гаргадаг. 2020-2021 онд эрхлэн гаргасан хэвлэл бүтээгдэхүүн:

№	ЖҮХ АА-аас эрхлэн гаргасан хэвлэл бүтээгдэхүүний жагсаалт
	Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргагүйн зөвлөмж /төрийн албан хаагчдад болон төрийн байгууллагаас бусад бүх хуулийн этгээдийн удирдлага, ажилтан, ажил олгогч иргэнд зориулав/
	Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал
	Салбарын жендэрийн бодлогод оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал
	Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин /сүүлийн үеийн тоо баримтаар/
	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт, төсөвлөлт
	Жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээрх орон нутгийн сайн туршлага
	Жендэрийн салбар хорооноос орон нутгийн хэмжээнд ЖЭТБХанган ажиллах удирдамж
	Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загвар
	Жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүн ажиллах журмын үлгэрчилсэн загвар
	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд ЖЭТБХангах үзэл баримтлалыг нэвтрүүлэх нь
	Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй удирдамж /редакцуудад зориулсан удирдамж/
	ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөвгүүд, эрчүүдийг татан оролцуулах сургагч багш бэлтгэх модуль хөтөлбөр
	Жендэр судлал №3-4
	Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага
	Жендэр ба нийгмийн ажил /нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулиудад зориулсан модуль сургалтын гарын авлага/
	Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй
	Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ
	Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ

/Ном эмхтгэлгэлийг www.ncge.gov.mn сайтын ном эмхтгэл хэсэгт/

5. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИК

Статистик үзүүлэлтүүд улсын дүн	Эмэгтэй	Эрэгтэй	Хугацаа
1. Монгол Улсын нийт хүн амын тоо	1 708 563	1 648 979	2020
2. Өрх толгойлсон хүн	70 304	16 221	2020
3. Төрөлтийн тоо	37 872	39 844	2020
4. Нас баралтын тоо	6 602	10 438	2020
5. Дундаж наслалт	76.22	66.71	2020
6. Нас баралтын зонхилох шалтгаан (зарим)			2020
Зүрх судасны тогтолцооны өвчин	2 251	280	
Хавдар	2 037	2 545	
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	5 57	2 270	
Амьсгалын тогтолцооны өвчин	519	654	
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	228	327	
7. 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо	555 320	633 120	2019 оны 4-р улирал
8. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	46.8%	61.6%	2021-3-р улирал
9. Ажилгүйдлийн түвшин	7.1%	8.3%	2018
10. Аж ахуйн нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин	1 212.8 мян. төг	1 439.9 мян. төг	2021 оны 2-р улирал
11. Ажлын байр дахь хүнд болон хөнгөн осол гэмтлийн давтамжийн хувь			2016
Үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан амь нас хохирсон	1%	9.1%	
Үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан амь нас хохироогүй	36.6%	61.8%	
12. СӨБ-ийн хамран сургалтын цэвэр жин	81,5%		2019
13. ЕБС-т өдрөөр суралцагчид	319 900	320 500	2019
14. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид	15 547	22 259	2019
15. Их, дээд сургууль, коллежид суралцагчид	89 463	57 830	2020
16. Гэмт хэргийн улмаас хохирогчдын тоо (насанд хүрэгчид)	13 205	15 979	2019
17. УИХ-ын гишүүд	13	63	2020

18. Засгийн газрын гишүүд	4 (квот хангагдсан)	10	2021
19. Дэд сайд нар	2	12	2021
20. Яамдын Төрийн нарийн бичгийн дарга	2	12	2021
21. Засгийн газрын агентлагийн дарга	3	33	2020
22. Яамдын газар, хэлтэс, албадын дарга	35% (квот хангагдсан)	65%	2020
23. ИТХ-ын дарга /аймаг, нийслэл/	2 9.1%	20 90.9%	2020
24. ИТХ-ын дарга /дүүрэг/	2 22.3%	7 77.7%	2020
25. ИТХ-ын дарга /сум/	53 16.1%	277 83.9%	2020
26. Засаг дарга /аймаг, нийслэл/	0	22	2020
27. Засаг даргын орлогч /аймаг, нийслэл/	8 19.1%	34 80.9%	2020
28. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	4 18.2%	18 81.8%	2020
29. Засаг дарга /дүүрэг/	1 11.2%	8 88.8%	2020
30. Засаг даргын орлогч /дүүрэг/	6 33.4%	12 66.6%	2020
31. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	1 11.1%	8 88.9%	2020
32. Засаг дарга/сум/	35 11.0%	295 89.0%	2020
33. Засаг даргын орлогч/сум/	51 15.5%	279 84.5%	2020
34. Жендэрийн хөгжлийн индекс	0,767	0,731	2020
35. Жендэрийн тэгш бус байдлын индекс	0,286		2020

Эх сурвалж: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, ҮСХ-ны 1212.тп, ЖҮХ АА, НҮБХХ-ийн 2019 оны Хүний Хөгжлийн илтгэл